



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ 2025 ОН

**НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв, /сая, төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /жилээр/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратегийн зорилго 1: Хотжилтын зорилтот түвшинг бүрэн хангана.							
Зорилт 1: Шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлж орон сууцжуулна. МУХТЖҮЧ-9.3,МУЗГҮАХ- 1.1.3.1, НХТЖҮЧ-9.2							
1.1	Сэлбэ дэд төвийг түшиглэн орон сууцжуулах төслийг үргэлжлүүлэх.	-	Төслийн хэрэгжилт	15%	50%	<p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/15 дугаар тогтоолоор “Сэлбэ хорин минутын хот корпораци” ХХК байгуулагдаж, дүрэм батлагдсан.</p> <p>Сүхбаатар дүүргийн 14,15 болон Чингэлтэй дүүргийн 14,18 дугаар хороодын 158 га талбай, 2,206 нэгж талбарт хэрэгжих “Сэлбэ дэд төв”-ийн төсөл 2025 оны 2 дугаар сард батлагдсан.</p> <p>2025 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар 1,994 нэгж талбараас 1,872-г буюу 94.1 хувийг 350 тэрбум төгрөгийн нөхөн олговортойгоор чөлөөлсөн байна.</p> <p>Төсөл нь 3 сургууль (3,780 хүүхэд), 5 цэцэрлэг (1,200 хүүхэд), эмнэлэг, 8,565 өрхийн орон сууцны 280 барилга, нийт талбайн 39 хувийн ногоон байгууламж бүхий Улаанбаатарын анхны “20 минутын хот” концепцтой.</p> <p>2025 онд Нийслэлийн үнэт цаасаар санхүүжих барилга угсралтын багцуудын гүйцэтгэчийг нээлттэй сонгон шалгаруулж, ЕРС гэрээнүүдийг байгуулсан. Гүйцэтгэлийн явц: зураг төсөл 95%, газар чөлөөлөлт 93 %, цэвэрлэгээ буулгалт 70.4%, гэрээлэлт 78.6%, барилга угсралт нийт 7%-тай хэрэгжиж байна.</p>	95

						Төслийн 47.25 га талбайд олон нийтийн үйлчилгээ, худалдаа, спорт, соёлын байгууламж төлөвлөн төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах удирдамж боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, газар чөлөөлөлт, зураг төсөл, үнэлгээний хороо, сонгон шалгаруулалтын зохион байгуулалтын талаар зөвлөмж боловсруулсан.	
Салбарын үр дүн: 1. Нийслэлийн орон сууцны хангамжийг 7000 өрхийн орон сууцаар нэмэгдүүлнэ. НХТ							
Зорилт 2: Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл төслийн хүрээнд ашиглалтад орсон орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. МУХТЖҮЧ-9.3, НХТЖҮЧ-9.6, 9.8							
2.1	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг үргэлжүүлэх.	Нийслэлийн төсөв 38,392.8	Ашиглалтанд орсон орон сууц	17,984	24,492	<p>Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нийт 26 байршлын 82 хэсэгчилсэн талбай батлагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 17 байршлын 40 хэсэгчилсэн талбай буюу нийт 851.05 га газарт 36 төсөл хэрэгжүүлэгч дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Тайлант оны жилийн эцсийн байдлаар инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан 3688 айлын орон сууц ашиглалтад шинээр орж 2014-2025 оны хооронд ашиглалтад орсон орон сууцны тоо өссөн дүнгээр 24513-д хүрээд байна.</p> <p>Тайлант онд ашиглалтад орсон орон сууцыг байршил, төсөл хэрэгжүүлэгчээр нь авч үзвэл: Үүнд: Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороо "Шинэ барилга" ХХК 60 өрхийн 1 блок орон сууц, Баянзүрх дүүргийн 12 дугаар "Б" хэсэгчилсэн талбай "Жигүүр гранд групп" ХХК 150 өрхийн орон сууц, Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороо Орон сууцны 14 дүгээр хороолол орчим "Е" хэсэгчилсэн талбай "Цагаан хуаран консалтинг" ХХК 135 өрхийн орон сууц, "З" хэсэгчилсэн талбай Таун констракшн ХХК 312 айлын орон сууц, "Б" хэсэгчилсэн талбай "Моннис урбан девелопмент" ХХК 330 өрхийн орон сууц, "Бүрд констракшны ГХДТ" ХХК 570 өрхийн орон сууц, Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хороо А хэсэгчилсэн талбай "Баганат өргөө" ХХК 517 өрхийн орон сууц, Баянгол дүүргийн 10, 11 дүгээр хороо "А" хэсэгчилсэн талбай Грийн ресурс констракшн ХХК 222 айлын орон сууц, "Б" хэсэгчилсэн талбай Очирням проперти девелопмент</p>	100

						ХХК 336 айлын орон сууц, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо Амгалан орчимд төсөл хэрэгжүүлэгч Грандлайн ХХК 240 айлын орон сууц, Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо “Б” хэсэгчилсэн талбай Пример инвестмент групп ХХК 96 айлын орон сууц, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо “Е” хэсэгчилсэн талбай "Андын зам констракшн" ХХК 360 айлын орон сууц, Баянзүрх дүүрэг 13, 14 дүгээр хороо “И” хэсэгчилсэн талбай Би Си Кей Си ХХК 360 айлын орон сууцыг тус тус байнгын ашиглалтад оруулсан байна.	
2.2	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийг үргэлжүүлэх	Нийслэлийн төсөв 9,229.7	Ашиглалтад орсон орон сууцны өрхийн тоо	3270	4311	<p>Иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах үндсэн эрхийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг олон удаа нийтэлсэн боловч санал ирэхгүй байгаа болон төсөл хэрэгжүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан иргэд хохирсон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 82 барилгыг Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-д, 25 барилгыг Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-д тус тус шилжүүлсэн бөгөөд төслийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт төсөл хэрэгжүүлэгчтэй 58 барилгаас 40 барилгын 1192 айлын орон сууцны барилгыг буулгаж, шинээр барилга барих ажил хийгдэж байгаа бөгөөд 18 барилгын 466 өрх 2 болон 3 талт гэрээ байгуулах шатанд байна.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн хүрээнд 2025 онд 43 байршилд 5427 айлын үйлчилгээтэй орон сууц ашиглалтад оруулсан.</p>	90
2.3	Дэд бүтцийн төв төслийг үргэлжүүлэх	Нийслэлийн төсөв 8,983.7	Дэд бүтцийн төв	3	5	<p>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 179 дүгээр тогтоолоор “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэх 50 байршлыг баталсан бөгөөд тус төслийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн 2 тэрбум юанийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 118 дугаар тогтоолоор “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэх эхний ээлжийн 16 байршлыг баталсан.</p>	90

					<p>Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Дэд бүтцийн төв” төслийн хамгийн эхний загвар төслийг 220 нэгж талбарыг хамарсан 14 га газарт амжилттай хэрэгжүүлсэн. Мөн Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд хэрэгжиж буй дэд бүтцийн төвийн эхний ээлжийн барилга угсралтын ээлжийн ажил 100 хувь дууссан бөгөөд 2 дугаар ээлжийн ажил 50%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Налайх дүүргийн 1 хороонд хэрэгжиж буй Дэд бүтцийн төв төслийн ажлын явц нь 75%-тай үргэлжилж байна. Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороонд хэрэгжих Дэд бүтцийн төв төслийн зураг төсвийн ажил боловсруулагдаж, магадлалын ерөнхий дүгнэлт гарсан. Хан-Уул дүүргийн 9-р хороонд баригдах дэд бүтцийн төвийн төсөвт өртөг 8.9 тэрбум, Баянзүрх дүүргийн 23-р хороонд баригдах дэд бүтцийн төвийн төсөвт өртөг 13 тэрбум, Сонгинохайрхан дүүргийн 4-р хороонд баригдах дэд бүтцийн төвийн төсөвт өртөг 9.9 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд Хан-Уул дүүргийн 9-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 4-р хороонд нийт 2 байршилд шинээр нэмж, дэд бүтцийн төв барьж байгуулах бөгөөд төсөвт өртөг 18.9 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд төсөл хэрэгжсэнээр 455 айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбож, хашаандаа тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2025 оны улс, нийслэлийн төсвийн төсөлд санал хүргүүлсэн ч төсөвт тусгагдаагүй.</p> <p>Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 52.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээг Монгол улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд санал хүргүүлээд байна.</p>	
--	--	--	--	--	---	--

Зорилт 3 :Түрээслээд өмчлөх болон орлогод нийцсэн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. /НХТЖҮЧ-9.7/

3.1	“Ногоон-Улаанбаатар орон сууцны төсөл”-ийг үргэлжүүлэх.	Гадаадын зээл	Төслийн хэрэгжилт	10%	30%	<p>Европын Сэргээн босголт, хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байгуулсан “Улаанбаатар хотын ногоон орон сууц” төслийн зээлийн хэлэлцээрийн ажлын хэсэгт орж, мэдээллээр тогтмол хангаж ажиллаж байна.</p> <p>Төслийн зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын хурлаар 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хэлэлцсэн. Төслийн удирдах хорооны 1 дүгээр хурлыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөөг тус тус баталсан. Төслийн загвар зургийг “GREEN ENGINEERING KZ LLP”-тай хамтран ажиллаж баталгаажуулсан.</p> <p>Төслийн нэгжийн гарын авлага, төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоо батлуулах ажлын хүрээнд төсөл боловсруулж, НЗДТГазарт хүргүүлж 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр батлуулсан. Төслийн нэгж 2024 оны 08-р сарын 02-ны өдрийн Монгол Улсын Сангийн сайдын 142 дугаар тушаалаар байгуулагдсан.</p> <p>2025 оны 03-р сарын 27 ны өдрийн Нийслэлийн Засаг даргийн А/386 дугаар захирамжаар Үнэлгээний хороо байгуулагдаж Тус төслийн урьдчилсан шалгаруулалтын тендерийг 2025 оны 05 дугаар сарын 11 өдөр зарласан. Тус тендерийн 1, 2 дугаар шатны сонгон шалгаруулалт дуусч 3 дугаар шатны сонгон шалгаруулалт явагдаж байна.</p>	96
3.2	“Баянгол ам түрээсийн орон сууцны хороолол барих төсөл”-ийг үргэлжүүлэх	Гадаадын зээл	Төслийн хэрэгжилт	15%	50%	<p>“Баянголын амын түрээсийн орон сууц төсөл”-ийн хүрээнд зураг төсөл боловсруулах, хяналт тавих болон чадавх нэмэгдүүлэх зөвлөх үйлчилгээ авахаар Бүгд Найрамдах Солонгос улсын “Аум энд Лий” консорциумтай 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр гэрээ байгуулж байсан ба тус төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Ил Сүнг” ХХК шалгарч, 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр гэрээг байгуулсан. Төслийн Удирдах хороог Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 01</p>	86

					<p>дүгээр сарын 29-ний өдрийн А/99 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулсан.</p> <p>Хийгдсэн ажлууд:</p> <p>Төслийн Удирдах хорооны дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан Нэгдүгээр орлогч дарга Т.Даваадалай ахласан ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр төслийн явцад хяналт шалгалт хийсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар тус төслийн үйл ажиллагааны талаар танилцуулсан.</p> <p>Баянголын ам түрээсийн орон сууцны хороолол барих төсөл"-ийн удирдах хорооны 1 дүгээр хурлыг 2025 оны 05 дугаар сарын 15-ний өдөр зохион байгуулж төслийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөөг тус тус баталсан</p> <p>Сонгинохайрхан дүүргийн 01 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 10 га талбайд 2007 өрхийн орон сууцны хороолол барих төслийн барилга угсралтын ажил 43%-тай хийгдэж байна.</p> <p>Тус төслийг Сангийн яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уялдаа холбоотой ажиллаж, тогтмол мэдээллээр ханган нийт 2 тайлан хүргүүлсэн.</p> <p>Төслийн нарийвчилсан зураг төсөв 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр төсөв батлагдсан бөгөөд төслийн барилга угсралтын ажлын техникийн нөхцөлийг 2024 оны 12 сард авсан. Оршин суугч сонгон шалгаруулах, менежментийн хөтөлбөр боловсруулах 3 боть тайланг зөвлөх үйлчилгээний "Аум ба Лий" консорциумаас 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдөр хүлээн авсан.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарын өгсөн үүрэг даалгаврын дагуу "Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл"-ийн хэрэгжилтийн явц удааширсан шалтгаан, нөхцөл байдлыг тогтоохоор Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай даргаар ахлуулсан шалгалтын бүрэлдэхүүн</p>	
--	--	--	--	--	--	--

						гарч 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт гарсан.	
3.3	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, бодлого, арга зүйгээр дэмжлэг үзүүлж ажиллана.	Гадаадын зээл Нийслэл	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	70%	90%	<p>“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, бодлого, арга зүйгээр дэмжлэг үзүүлж сар, улирлын тайлантай танилцан, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд санал өгөн ажилласан.</p> <p>Төслийн 2 дугаар үе шат</p> <p>Дамбадаржаа дэд төвийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 297 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 296 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 98%-тай байна. Авто зам инженерийн барилга байгууламжийн ажлын трасст өртсөн 1 өрх эд хөрөнгийн өмчлөлийн маргаантай, шүүхдэж байгаа тул хэлэлцээр эцэслэн хийгдээгүй хүлээгдэж байна. Шүүхийн шийдвэр гарахаар хэлэлцээр хийгдэнэ.</p> <p>Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил бүрэн хэрэгжиж дууссан байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны явц 98%-тай байгаа бөгөөд 63МВт-ын дулааны станцын зөвлөх үйлчилгээний 1 багц ажил, 58-р сургууль орчмын орц, гарц, гадна тохижилтын 1 багц ажил болон цэцэрлэгийн тавилга худалдан авах 1 багц ажил үлдсэн байна.</p> <p>Дамбадаржаа дэд төвийн барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: 2.8 км авто замын ажлын явц 90%</p> <p>63МВт-ын хүчин чадалтай дулааны станцын барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 20%-тай байгаа бөгөөд Эрчим хүчний яамнаас ажил эхлүүлэх зөвшөөрөл 2025 оны 3 сарын 6-нд гарсан. 21МВт-ын 3 зуух болон метал хийц, бусад голлох тоног төхөөрөмжүүдийн гадаад захиалга хийгдээд байна.</p>	95

					<ul style="list-style-type: none"> • 2.15 км дулааны шугам сүлжээний ажлын явц 83%, 4ш ус дулаан дамжуулах төвийн барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 90% • 6.6 км цахилгааны шугам сүлжээ, 5.9 км холбооны сувагчлал, 4.8 км шилэн кабель, 1 хуваарилах байгууламж, 2 хаалттай дэд өртөө болон мэдээлэл холбооны сүлжээний нэгдсэн үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлын явц нийт 57.4% байгаа бөгөөд “Авто зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрөл олгох” ажлын хэлтсийн хурлаар орж зам сэтлэх, сүвлэх зөвшөөрөл авах шаардлагатай хурлын тов хүлээгдэж байна. • 2.24 км цэвэр усны, 3 км ариутгах татуургын шугам сүлжээний ажлын явц 82% • 1.2 км хөрсний ус доошлуулах шугамын угсралтын ажлын явц 78% • 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц 83%-тай байна. <p>Дэд төвийн бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц 62.4%-тай байна.</p> <p>Төслийн 3 дугаар үе шат (2021.03.15-2026.12.31)</p> <p>Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3, 34, 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт Толгойт дэд дэд төвийн 138 га талбайд, Баянзүрх дүүргийн 8,9,10,17,19,24 дүгээр хорооны нутаг дэвгэр дэх “Шархад дэд төвийн 124 га талбайд инженерийн болон нийгмийн барилга байгууламжийг барьж байгуулна. Толгойт дэд төвийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 501 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 472 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 96.1%-тай байна. Авто зам инженерийн барилга байгууламжийн ажлын трасст өртсөн 1 өрх эд хөрөнгийн өмчлөлийн маргаантай тул хэлэлцээр эцэслэн хийгдээгүй байна. Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 98%-тай хэрэгжиж байна.</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>Худалдан авах ажиллагааны явц 85%-тай байгаа бөгөөд Толгойт дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн 4 багц ажил, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 2 барааны худалдан авалт үлдсэн байна.</p> <p>Толгойт дэд төвийн барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 1.8 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 95%-тай байна. • 5.2 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 46%-тай байгаа бөгөөд Д-1, Д-2.1, Д-2.3 үерийн хамгаалалтын сувгийн угсралтын ажил хийгдэж байна. • 2.84 км цэвэр усны шугам сүлжээний ажил болон насос станцын барилга угсралтын ажил 100% дууссан. • 10 кВ-ын хүчдэлийн 13 км урттай 4 хос цахилгааны кабель шугам, 2 хаалттай дэд өртөө болон 1 хувиарлах байгууламжийн ажлыг гүйцэтгэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлаа эхлүүлсэн. Хаалттай дэд өртөө болон хуваарилах байгууламжийн суурийн арматурчлал болон цутгалтын ажил хийгдэж барилга угсралтын ажлын явц 5%-тай байна. • Сургалтын төвийн барилга угсралтын ажлын явц 100% дууссан. • 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлын явц 45%-тай байна. <p>Дэд төвийн бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц 58.8%-тай байна.</p>	
3.4	"Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох бүхий хотын шинэчлэл төсөл"-ийн олон улсын зөвлөх үйлчилгээ, нүүлгэн шилжүүлэлт, байгаль	Гадаадын зээл	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90%	100%	<p>"Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох бүхий хотын шинэчлэл төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд Баянхошуу Б15 талбарын эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажлын явц 96%, тус талбарын инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын явц 100%-ийн хэрэгжилттэй, улсын комисст 2024 оны 12 дугаар сарын 26-нд хүлээлгэн өгсөн.</p>	90

	<p>орчны хөндлөнгийн хяналт, үнэлгээ, түр нүүлгэн шилжүүлэх барилгууд болон халамжийн орон сууцны барилга, инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.</p>					<p>Баянхошуу дэд төвийн 2024 оны 7 сараас эхлүүлсэн Б13-1 талбарт баригдаж буй 150 айлын барилга угсралтын ажил 40 хувь, 2024 оны 10 сараас эхлүүлсэн Б13-2 талбарт баригдаж буй 76 айлын барилга угсралтын ажил 20%-тай байна.</p> <p>Шархад дэд төвийн S27-5 талбарын эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажлын явц 97%-ийн хэрэгжилттэй байна. Тус дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын явц 100%-тай байна.</p> <p>Шархад дэд төвд 2024 оны 7 дугаар сараас эхлүүлсэн S27-2 талбарт баригдаж буй 152 айлын барилга угсралтын ажил 40%-ийн хэрэгжилттэй, 2025 оны 3 дугаар сараас эхлүүлсэн 76 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 10%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Барилга угсралтын 16 гэрээ, Зөвлөх үйлчилгээний 2 гэрээг хянан баталгаажуулсан.</p>	
<p>Зорилт 4. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, үүрэг даалгаврын холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, хянах, тайлагнах, авлига үүсэх эрсдлийг бууруулах, хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, хүний нөөцийн хөгжлийн болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийг баяжуулж, цахим сан бүрдүүлэх, албан хаагчдад мэргэжил, арга зүйн заавар зөвлөгөө өгөх, Төсөв санхүүг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах болон бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод хяналт хийх, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх.</p>							
4.1	<p>Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.</p>	-	Хэрэгжилтийн хувь	90%	100%	<p>Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 58 дугаар тушаалаар байгуулагдсан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийг дагалдуулан баталсан журам, гэрээний загварын нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/715 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p>	98

					<p>Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийн бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, “Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллыг хөгжүүлэх сан” байгуулах эрх зүйн харилцааг зохицуулсантай холбоотойгоор сангийн журам боловсруулах ажлын хэсэгт орон сууцны нийлүүлэлтийн төлөвлөгөө, судалгаа, орлого бүрдүүлэлтийн тооцоо мэдээллийг гарган өгч, журамд санал тусган хамтран ажилласан ба нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэгдэж, батлагдсан.</p> <p>Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө–2040”-т олон улсын зээл, дэд төвүүдийг түшиглэн хэрэгжүүлэх гэр хорооллыг орон сууцжуулах төслөөр нийт 65,000 өрхийн орон сууц барихаар тусгав. Мөн Баянголын ам, Ханын материал зэрэг өмнө тусгагдаагүй бүсүүдийг төлөвлөлтөд шинээр оруулсан.</p> <p>Улаанбаатар хотын агаар, орчны бохирдол, түгжрэлийг бууруулах зорилгоор “Гэр хорооллыг хөгжүүлэх, газар чөлөөлөх сан”-г байгуулахтай холбоотойгоор Улаанбаатар хотод 2040 он хүртэл гэр хорооллыг орон сууцжуулах төлөвлөгөөний дагуу архитектур орон зайн бүсчлэлийн зураглал боловсруулав.</p> <p>Тус газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, Газар зохион байгуулалтын алба, Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар болон Бодлогын судалгаа, шинжилгээний төвтэй хамтран ArcGis программд суурилсан дотоодын мэдээллийн санг үүсгэж, баяжуулалтыг тогтмол хийж ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг Даргын 2025 оны А/766 дугаар захирамжаар Нийслэлийн Ерөнхий архитекторын дэргэд Улаанбаатар хотын орон сууцжуулах төслүүдэд тулгамдаж байгаа асуудалд санал, дүгнэлт гаргах, шийдлийг боловсруулах байнгын ажиллагаатай Ажлын хэсгийг</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>байгуулсан бөгөөд Нарийн бичгийн даргаар Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн С.Амаржаргал ажиллаж байна. Ажлын хэсгийн хүрээнд 2 удаагийн хурал зохион байгуулсан бөгөөд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:</p> <p>“Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-тэй орон сууцжуулах төслүүдийн нягтаршил, хүн амын тоог уялдуулж, 2040 он хүртэл олон улсын зээл, тусламжаар баригдах болон дэд төвийг түшиглэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийн хүрээнд 65,000 өрхийн орон сууцыг ашиглалтад оруулахаар тусгасан. Тодруулбал, Нийслэлийн “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын Хот төлөвлөлтийн хэлтэс болон Эдийн засаг, судалгааны хэлтэстэй хамтран “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-ийн хүн амын нягтаршил, орон сууцны өрхийн тоог 42 нэгж хорооллын хүн амтай уялдуулж, уг төлөвлөлтөд тусгагдаагүй үлдсэн байсан Баянголын ам, Ханын материал зэрэг орон сууцжуулах төслүүдийг төлөвлөлтөд тусгаж ажилласан.</p> <p>➤ Улаанбаатар хотын агаар, орчны бохирдол, түгжрэлийг бууруулах зорилгоор “Гэр хорооллыг хөгжүүлэх, газар чөлөөлөх сан”-г байгуулахтай холбоотойгоор Улаанбаатар хотод 2040 он хүртэл гэр хорооллыг орон сууцжуулах төлөвлөгөөний дагуу архитектур орон зайн бүсчлэлийн зураглал боловсруулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хотын төвийн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг соёлын өвд авах талаарх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд: Соёлын өвд бүртгэх үйл ажиллагаатай холбоотой журмын төсөлд санал өгч төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах; 2. Соёлын өвд бүртгэх орон сууцыг тодорхойлох; 3. Ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг ашиглахыг хориглосон Хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын шийдвэрийг дахин нягтлах, хүчитгэх боломжтой эсэх талаар ангилах; 4. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг хүчитгэх боломжуудыг судлах; 	
--	--	--	--	--	---	--

					<p>5. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны үр ашгийн тооцоо гаргах зэрэг ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>➤ Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны хүрээнд:</p> <p>1. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулж буй 37 төсөл хэрэгжүүлэгчийн төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн альбомыг боловсруулж, нэгтгэсэн.</p> <p>Гэр хорооллыг орон сууцжуулах төслийн хүн амын нягтаршлыг “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-тэй харьцуулсан судалгааг хийж, ажлын хэсэгт танилцуулсан.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай байрыг буулган шинээр барилгажуулах үйл ажиллагааны хүрээнд 204 төсөл хэрэгжиж байна.</p> <p>Үүнд: Нийслэлийн Орон сууцны бодлогын газар - 58 “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК - 82 Нийслэлийн Орон сууцны корпораци ХК – 25</p> <p>2025 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргаар 171 гурван талт гэрээ батлуулсан бөгөөд гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 4311 өрхийн орон сууцыг ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс 5427 өрхийн орон сууцыг ашиглалтад оруулсан.</p> <p>Гэр хорооллын дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд 2025 онд 24492 өрхийн орон сууцыг ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс нийт 24513 айлын орон сууц ашиглалтад оруулсан.</p> <p>Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд улс, нийслэл болон бондын хөрөнгө оруулалтаар гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>угсралтын ажилд нийт 196.9 тэрбум төгрөг төсөвт суулгуулсан байна.</p> <p>Нийслэлийн Засаг Даргын 2024 оны А/691 дүгээр захирамжаар байгуулагдсан Хяналтын хорооны 4 удаагийн хурлаар 11 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс ирүүлсэн гомдол саналыг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, 7 (“Баганат өргөө” ХХК, “Грандлайн” ХХК, “Андын зам” констракшн ХХК, “Бүрд констракшны ГХДТ” ХХК, “Грийн ресурс констракшн” ХХК, “Очирням проперти девелопмент” ХХК, “Бармон” ХХК) төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжид хугацаатай үүрэг даалгавар өгч 4 (“Голден мартин” ХХК, “Монголиан инвестмент корпорейшн” ХХК, “Газрын эзэн Баянзүрх” ЗБН, “Ланкастер” ХХК) төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах тухай Нийслэлийн Засаг Даргын 2025 оны А/557, А/558, А/639, А/640 дугаар захирамж гарсан.</p> <p>“Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл”, “Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл” “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-болон “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, түрээсийн олон төрөлт болон орлогод нийцсэн ногоон орон сууцны шинэ хорооллуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх бодлого, арга зүйгээр дэмжлэг үзүүлж ажиллаж байна.</p>	
4.2	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах,	-	Хэрэгжилтийн хувь	90%	100%	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тус газрын 2025 оны 01/846, Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлтийг 01/786, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан гэрээний биелэлтийг 01/7977, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 01/923 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>Мөн Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол,</p>	90

	ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих, инженерийн болон нийгмийн дэд бүтэцтэй холбоотой дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлнэ.					Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал” болон 2023 оны “Журам болон аргачлалд өөрчлөлт оруулах тухай” 264 дүгээр тушаалын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системд үнэлгээ хийж, илгээсэн.	
4.3	Хот, суурин газрыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтыг хяналтад авч хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлнэ.	-	Хяналт, шинжилгээ хийгдсэн дүн	80%	90%	Хот, суурин газрыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд байгууллагын дүрмээр хүлээсэн нийт 12 чиг үүрэгтэй. Үүнд: Хот, суурин газрыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд-3 1. Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр -2 2. Дахин хөгжүүлэх төслүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр-3 3. Нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр-2 Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний чиглэлээр -2 гээд тус тус 12 үндсэн чиг үүрэг байна. Дээрх чиг үүрэгтэй холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтыг тус газрын 4 хэлтэс хэрэгжүүлэн мөрдөн хяналтад авч, тайлагнаж ажиллаж байна.	90
4.4	Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаварыг Нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.	-	Шүүхийн маргааны шийдвэр, явц	100 %	100%	Тайлант хугацаанд нийт 22 маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн оролцов. Үүнээс Захиргааны хэргийн шүүхэд 10, иргэний хэргийн шүүхэд 12 маргаан байна. Эдгээр маргаанаас анхан шатны шүүхэд 19, давж заалдах шатанд 3 маргаан, хэрэг үүсэхээс татгалзсан 8 маргаан байна. Тайлант хугацаанд шинээр 5 хэрэг үүсэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд 14 маргаан хянагдаж байна.	100
4.5	Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын	2,016.2	Гүйцэтгэлийн хувь	100 %	100%	1.Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор үнэн зөв гаргаж, Нийслэлийн Төрийн санд цаг	100

	дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана.	сая төгрөг				хугацаанд нь хүргүүлж, төсвийн шууд зардлын өр авлагагүй, зардлын хэтрэлгүй ажилласан. 2.Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 05-ны өдөр дотор гаргаж, цахим системд оруулан баталгаажуулалт хийж ажилласан. 3.Хувь хүний орлогын албан татварын 1 дүгээр улирлын тайланг хуулийн хугацаанд нь гарган татварын нэгдсэн системд шивж оруулсан. 4.Тайлант хугацаанд төсөвлөсөн орлого болох 1,482.5 мян.төгрөгийн 78,4% буюу 1,163.3 мян.төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, 319.2 мян.төгрөгийн хэмнэлттэй ажилласан.	
4.6	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөө боловсруулан батлаж хэрэгжилтийг хангуулна.	-	Хэрэгжилтийн хувь	90%	100%	Газрын хүний нөөцийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд нийт 25 албан хаагчаас сургалтын хэрэгцээг тодорхойлох, цаашид суралцах шаардлагатай сургалтын саналыг авсны дагуу Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтэстэй хамтран нийт 38 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 142 албан хаагчийг хамруулсан. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний дагуу 25 албан хаагчид Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын дагуу цалин хөлсийг шинэчилсэн хэмжээгээр олгож байна. Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачаалал, түүнээс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, албан хаагчдын ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Газрын даргын 2025 оны А/10 дугаар тушаалын дагуу 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажлын цагийн хуваарьт уян хатан байдлыг бүрдүүлэн ажилласан. Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу: <input type="checkbox"/> Буцалтгүй тусламж-10 <input type="checkbox"/> Зэрэг дэвийн нэмэгдэл-6 албан хаагчид олгосон байна.	100
4.7	Дээд шатны байгууллага болон аудитын дүгнэлт, хяналт-шинжилгээний зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган, биелэлтийг хангуулж ажиллана.	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	Санхүүгийн тайланд өгсөн 2024 оны аудитын 4 зөвлөмжийн хүрээд Нийслэлийн Орон сууцны санхүүгийн тайлангийн нөөцийн бараа дансанд бүртгэлтэй байгаа 556747.8 м.кв 7,882,044.1 мянган төгрөгийн газрын эзэмших эрхийг НЗДТГазарт шилжүүлэх Зөвлөлийн хуралд оруулахаар бэлтгэл ханган ажиллаж, ажил хавсран гүйцэтгэж байсан 10 албан хаагчийг цөөрүүлж 4 албан хаагч болсон, цахим	100

						дэлгүүрээс худалдан авалтийн төлөвлөгөөг оруулсан боловч худалдан авах бараа ороогүй байна. Мөн шууд худалдан авалтын 16,800,000 төгрөгийн төлөвлөгөөг tender.gov.mn системд тайлагнаж зөвлөмжийг ханган ажилласан байна. Хэрэгжилт 100%-тай байна	
4.8	Монгол Улсын Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02/03 дугаар албан шаардлагад заасан зөрчил, дутагдлыг арилгах талаар төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж, тогтоосон хугацаанд тайлагнана.	-	Гүйцэтгэлийн хувь	-	100%	<p>Тус шаардлагын дагуу зөрчил дутагдлыг арилгах үүрэг бүхий Ажлын хэсгийг газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулсан. Нийт 9 шаардлага ирүүлсэн бөгөөд иргэний гомдлыг Хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж, 2025/01 дүгээр шийдвэр гаргуулсан, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах зорилгоор дотоод хяналт шалгалтыг сар тутам хийх төлөвлөгөөг баталж, албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “өргөдөл, гомдлыг бүрэн судалж, хууль зүйн үндэслэлтэй, хариу өгч, холбогдох мэдээ, мэдээллээр хангаж, зөрчилгүй ажиллана” гэсэн арга хэмжээг тусгасан.</p> <p>Газрын даргын 2025 оны Б/19, Б/20 дугаар тушаалаар хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 4 зөрчлийг арилгасан, даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар ажлын цагт уян хатан зохицуулалт хийх зэрэг холбогдох бусад арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p> <p>Тус албан шаардлагын хэрэгжилтийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 01/172 дугаар албан бичгээр тогтоосон хугацаанд хүргүүлсэн.</p> <p>Нийт хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/162 дугаар албан бичгээр, Монгол Улсын Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/172 дугаар албан бичгээр тус тус тайлагнасан.</p> <p>Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төсөл хэрэгжүүлэгч “Баганат өргөө” ХХК-д холбогдох иргэн Л.Сайнтуяагийн гомдолд дурдсан асуудал болон Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11.1.4, 26.4.1-т заасныг зөрчсөн асуудлыг Хяналтын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус хурлын хурлын шийдвэрээр төсөл хэрэгжүүлэгч “Баганат өргөө” ХХК-д</p>	90

						<p>хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Хяналтын хорооны өгсөн хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилт хангаж ажиллах тухай мэдэгдлийг 03/188 дугаар албан бичгээр “Баганат өргөө” ХХК-д, иргэн Л.Сайнтуяад Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлж газар, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой баримт бичгийн зөрчлийг арилгаж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг 03/185, 03/186 дугаар албан бичгээр мэдэгдсэн. Иргэн Л.Сайнтуяа болон төсөл хэрэгжүүлэгч Баганат өргөө ХХК-ний хороонд гурван талт гэрээ байгуулах зөвшилцөх уулзалтыг 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. Мөн Хяналтын хорооны 08 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар уг асуудлыг дахин хэлэлцэн хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.</p>	
4.9	<p>Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ.</p>	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	<p>Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Захиалагчийн хяналт тавих тухай” А/164 дүгээр захирамжаар гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний гэрээт 11 төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэж, захиалагчийн хяналтыг хийх үйл ажиллагааг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т даалгасан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/164 дүгээр захирамжаар батлагдсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажлын жагсаалтад өөрчлөлт оруулах саналыг хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/908 дугаар захирамжаар нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээний төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталж, худалдан ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах</p>	90

						<p>ажиллагааны газарт шилжүүлсэн. Захирамжаар батлагдсан 5 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч, гэрээ байгуулагдсан бөгөөд жагсаалтын “2”, “4” дахь заалтад тусгасан 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2 удаа зохион байгуулсан боловч нэг ч оролцогч тендер ирүүлээгүйн улмаас амжилтгүй болсон байна.</p> <p>Байгууллагын зүгээс дээрх асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр холбогдох байгууллагуудын удирдлагуудыг оролцуулан хурлыг зохион байгуулсан бөгөөд тус хурлаар Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/908 дугаар захирамжаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1313, А/1314 дүгээр захирамжаар шинэчлэн батлуулсан.</p> <p>Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх шаардлагатай гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний 8 төсөл, арга хэмжээний 21.6 тэрбум төгрөгийн саналыг хүргүүлж, эрх шилжүүлэх тухай захирамжууд гарч, холбогдох байгууллагууд руу шилжсэн.</p> <p>Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь. info.shilendans.gov.mn мэдээлэл тогтмол оруулж байна.</p>	
4.10	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг	-	Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан гүйцэтгэлийн хувь	100 %	100%	Тус газрын Авлигын эсрэг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Газрын даргаар батлуулсан. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газарт 2024 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийг 2025 оны 01 дүгээр сард хүргүүлсэн. ХАСХОМ гаргах нийт 12 албан хаагчийн мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан	100

	хэрэгжүүлэх зорилгоор авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ зохион байгуулах, биелэлтийг хангана.					<p>www.meduuleg.iaac.mn мэдүүлгийн бүрдүүлэлтийн программд оруулж, баталгаажуулалтыг бүрэн хийсэн. Авлигатай тэмцэх газрын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн системд төрийн захиргааны албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд оруулж, нэгтгэн хураангуй тайланг ХАСХОМ-1, ХАСХОМ-2, маягтаар 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 01/245 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах шинээр томилогдсон 12 албан хаагчаас хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан Авлигатай тэмцэх газраар хянуулж, ирсэн дүгнэлтийг үндэслэн томилсон.</p> <p>Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас ЭБАТ-д зориулан зохион байгуулсан 4 удаагийн сургалтад хамрагдсан.</p>	
4.11	Хот, суурин газрыг хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төсөл хэрэгжүүлэгчийг дэмжих эсэх санал авах ажиллагааг зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэгчийн эрхийг баталгаажуулж, албажуулах ажлыг зохион байгуулна.	-	Төсөл хэрэгжүүлэгчийн тоо	0	48	<p>Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу 2015 оноос хойш Нийслэлийн Засаг даргын 22 удаагийн захирамжаар 208 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах тухай шийдвэр гарснаас 2025 онд Нийслэлийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар 22 барилгын дахин төлөвлөн барилгажуулах шийдвэр гарсан.</p> <p>Иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах үндсэн эрхийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг олон удаа нийтэлсэн боловч санал ирэхгүй байгаа болон төсөл хэрэгжүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан иргэд хохирсон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 82 барилгыг Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-д, 25 барилгыг Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-д тус тус шилжүүлсэн бөгөөд төслийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.</p>	95

						Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нийт 26 байршлын 82 хэсэгчилсэн талбай батлагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 17 байршлын 40 хэсэгчилсэн талбай буюу нийт 851.05 га газарт 36 төсөл хэрэгжүүлэгч дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа явуулж байна.	
4.12	Улс, нийслэлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт санал боловсруулж тусгуулна.	-	Саналын тоо	6	7	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/766 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-г боловсруулж байгаатай холбоотойгоор нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын Хот төлөвлөлтийн хэлтэс, Эдийн засаг, судалгааны хэлтэстэй хамтран хүн амын нягтаршил, орон сууцны өрхийг 42 нэгж хорооллын хүн амтай уялдуулж, уг төлөвлөлтөд тусгагдаагүй үлдсэн байсан Баянголын ам, Ханын материалын зэрэг орон сууцжуулах төслүүдийг уг төлөвлөгөөнд тусгаж ажиллав. Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголыг боловсруулж байгаатай холбогдуулан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хүрээнд хэрэгжиж буй ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төслийн хэрэгжилттэй уялдуулан газар эзэмших эрх шинээр баталгаажуулах саналыг тусгаж ажиллаж байна.	95
4.13	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төсөл хэрэгжүүлэх байршилд 2026 онд хэрэгжих инженерийн шугам сүлжээний зураг төсөв, барилга угсралтын ажлын	-	Саналын тоо	3	3	Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал” болон 2023 оны “Журам болон аргачлалд өөрчлөлт оруулах тухай” 264 дүгээр тушаалын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системд үнэлгээ хийж, илгээсэн.	90

	шаардлагатай хөрөнгө оруулалтын саналыг боловсруулж, холбогдох газарт хүргүүлнэ.					Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хүрээнд хэрэгжих гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл болон Нийслэлийн Орон сууцны корпорац ХК, Улаанбаатар орон сууцжуулалт ХХК-ийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл, дэд бүтцийн төвийн барилга байгууламж барих зэрэг зураг төсөл, барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр 154.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй 50 төсөл, арга хэмжээний санал хүргүүлсэн боловч 19.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй 9 төсөл, арга хэмжээг 2026 онд шийдвэрлэхээр дэмжсэн болно	
4.14	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, тайлангийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж ажиллана.	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	<p>Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч “Хера пропертийз” ХХК, “Очирням проперти девелопмент” ХХК, Ама констракшн ХХК, “Хера холдинг” ХХК, “Би Си Кэй Си” ХХК-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5 тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 3 тогтоолоор нийслэл хотын хэмжээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх 26 байршил, 82 хэсэгчилсэн талбайг баталсан. Энэ нь 19,844 нэгж талбар буюу 1656.15 га газрыг эзэлж байна. Тус байршлуудад батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 148,323 айлын орон сууц, 60 сургууль, 92 цэцэрлэг, 14 эмнэлгийг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. 2025 оны жилийн эцсийн байдлаар төсөл хэрэгжүүлж буй 17 байршил 40 хэсэгчилсэн талбайд 36 төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж барилга угсралтын ажил гүйцэтгэж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/539 дүгээр захирамжаар батлагдсан нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дүрмийн дөрөв дэх хэсэгт газрын үндсэн чиг үүргийн 4.3.1-д зааснаар</p>	90

						<p>ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, төсөл хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагааны зөрчил гаргасан эсэх тухай дүгнэлтийг хууль тогтоомжийн хүрээнд гаргаж Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/691 дүгээр захирамжаар байгуулагдсан Хяналтын хорооны 8 удаагийн хурлаар давхардсан тоогоор 22 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс ирүүлсэн гомдол саналыг хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж 8 төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж (Баганат өргөө ХХК, Грандлайн ХХК, Андын зам констракшн ХХК, Бүрд констракшны ГХДТ ХХК, Грийн ресурс констракшн ХХК, Очирням проперти девелопмент ХХК, Бармон ХХК, Мөнгөн тулга цамхаг ХХК)-д хугацаатай үүрэг даалгавар өгч, 5 төсөл хэрэгжүүлэгч (Голден мартин ХХК, Монголиан инвестмент корпорейшн ХХК, Ланкастер ХХК, Газрын эзэн Баянзүрх ЗБН, Андын зам констракшн ХХК) аж ахуй нэгжийн төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах тухай Нийслэлийн Засаг Даргын 2025 оны А/557, А/558, А/639, А/640, А/1161 дүгээр захирамж гараад байна.</p>	
4.15	<p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төсөл хэрэгжүүлэгчдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, тайлангийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж ажиллана.</p>	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	<p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих үйл ажиллагааны хүрээнд төсөл хэрэгжүүлэгч “Төгс прогресс” ХХК, “Профессионалстрой” ХХК, “Хару констракшн” ХХК, “Хан хөгшин стэйт” ХХК, “Эх газрын жигүүр” ХХК,” Монтед констракшн” ХХК-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор 20 удаагийн уулзалтаар 2000 гаруй иргэдтэй гурван талт уулзалтыг зохион байгуулсан.</p>	90
4.16	<p>Нийслэлийн удирдах ажилтны болон салбарын</p>	-	Хэрэгжилтийн хувь	90%	100%	<p>Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн</p>	100

	удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, тайлагнах, хяналт тавина.					байдлаар Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн нийт 19 удаа зохион байгуулагдсан. Үүнээс 43 үүрэг даалгаврын биелэлтийг гарган удирдлагаар хянуулан шуурхайн өмнөх 7 хоногийн 4 дэх өдөр бүр ERP системийн хяналт шинжилгээ үнэлгээ газарт биелэлтийг хүргүүлсэн. Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт 100%	
4.17	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	-	Тарьсан модны тоо /ширхэг/	48	50	Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд хэрэгжүүлэх Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Ногоон хот-Иргэний оролцоо хаврын мод тарих аяны хүрээнд Налайх дүүргийн 7 дугаар хороо Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд хавар 25 ширхэг мод, 10 дугаар сарын 17-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 24 ширхэг шар хуайс, буйлс мод нийт 49 ширхэг мод тарьсан.	100
4.18	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100 %	100%	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр батлуулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан “Жендэрийн тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо” сэдэвт сургалтад нэг албан хаагч, 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Жендэрийн тэгш байдлыг бий болгоход хэвшмэл хандлага, сөрөг нөлөөлөл, ёс зүйн мэдлэг олгох сургалтанд 2 албан хаагч, Нийслэл дэх Жендерийн салбар хорооны хуралд 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр 1 албан хаагчийг тус тус хамруулсан. Мөн “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдэцгээе” уриатай 16 хоногийн нөлөөллийн аяныг зохион байгуулсан.Тайлант хугацаанд байгууллагын албан хаагчид ажлын байрандаа жендэрийн ялгаварлан гадуурхалтын тухай гаргасан гомдол, саналгүй болно.	100
4.19	“Ногоон барилгын гэрчилгээ олгох журам” болон ногоон, эрчим хүчний хэмнэлттэй амины	-	Хэрэгжилтийн хувь	100 %	100%	Баянхошуу, Шархад дэд төвд баригдаж буй ногоон, эрчим хүчний хэмнэлттэй 800 өрхийн орон сууцны барилгын угсралтын ажилтай Нийслэлийн Ерөнхий архитектор болон	95

	<p>орон сууц барихтай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд сурталчилж, холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.</p>					<p>холбогдох албаны мэргэжилтнүүдтэй хамтран танилцаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хүргэн ажилласан.</p> <p>“Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн 2025 оны тайлангийн “Улаанбаатар ба” 9 дүгээр бүлгийн төлөвлөлт төвтэй шийдэл болон орчин төвтэй шийдэл хэсэгт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй барилгын талаарх мэдээллийг стандартын дагуу боловсруулан оруулж, иргэд, олон нийтэд сурталчлах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Ногоон, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихтай холбоотой 14 мэдээ, мэдээллийг газрын фэйсбүүк хуудас https://www.facebook.com/profile.php?id=61566563750022 болон албан ёсны нүүр хуудсаар https://hpa.ub.gov.mn/ дамжуулан тухай бүрд сурталчилж таниулсан.</p> <p>Барилга Экспо 38 дахь удаагийн арга хэмжээ 2025 оны 9 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд Буян Ухаа спорт цогцолборт зохион байгуулагдсан бөгөөд уг арга хэмжээнд нийслэлээс хэрэгжүүлж буй орон сууцны төслүүдийн талаарх мэдээллийг давхардсан тоогоор 1,000 гаруй иргэдэд хүргэв</p> <p>Мөн барилгын эрчим хүчний үр ашиг, Ногоон Барилгын Үнэлгээний Системийг олон нийтэд таниулах, барилгын салбарын мэдлэг, чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Орон сууцны дэд бүтцийн хэлтсийн 2 мэргэжилтнийг сургалтад хамруулсан.</p> <p>Барилгын эрчим хүчний үр ашиг, Ногоон Барилгын Үнэлгээний Системийг олон нийтэд таниулах, барилгын салбарын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ын “Ногоон барилгын үнэлгээний Excellence in Design for Greater Efficiencies (EDGE) систем”-ийн дотоодын мэргэшсэн эксперт бэлтгэх зохион байгууллаа. Сургалтад төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан.</p> <p>Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ын “Ногоон барилгын үнэлгээний Excellence in Design for Greater Efficiencies (EDGE) систем”-ийн дотоодын мэргэшсэн эксперт бэлтгэх хоёр дахь удаагийн сургалтыг</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>2024/01/18-19 өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан.</p> <p>Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ын “Ногоон барилгын үнэлгээний Excellence in Design for Greater Efficiencies (EDGE) систем”-ийн дотоодын мэргэшсэн эксперт бэлтгэх хоёр дахь удаагийн сургалтыг 2025 онб 01 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжийн төлөөлөл хамрагдсан.</p>	
4.20	Улаанбаатар хотыг ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	-	Хэрэгжилтийн хувь	100 %	100%	<p>Нийслэл Улаанбаатар хотыг ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт “Нью Урбанизм” ХХК шалгарч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр НХААГ820250103601 дугаартай гэрээг үзэглэсэн ба захиалагчийн хяналтыг нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар гүйцэтгэж байна.</p> <p>“Нью урбанизм” ХХК нь гүйцэтгэгчээр шалгарсан тул мэдээлэл авах хүсэлт ирүүлсний дагуу 2025 оны 7 дугаар сарын 25-нд нийслэлд хэрэгжүүлж байгаа орон сууцны төслүүдийн хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар танилцуулга хийсэн ба нийт 3 удаагийн уулзалт хийж, мэдээллээр хангаж ажиллав.</p> <p>Гүйцэтгэгч нь гэрээнд заасны дагуу эхлэлийн тайланг 2025 оны 7 дугаар сарын 16-ны дотор ирүүлэх байсан боловч 10 дугаар сарын 15-ны өдөр нийслэлийн Орон сууцны бодлогын газарт ирүүлсэн ба уг тайлан нь шаардлага хангахгүй байгаа тул хүлээж авахаас татгалзсан.</p>	85
4.21	Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ	-	Цахим системд тайлагнасан төсөл, арга хэмжээний тоо	-	Төсвийн жилд дууссан даруйд зохион байгуулсан нийт төсөл, арга	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажлын хүрээнд тус газрын Харуул хамгаалалтын тендерийн төлөвлөгөөг https://user.tender.gov.mn/mn/admin/index-д оруулан батлуулж, тендерийн зарыг газрын веб хуудсанд https://hpa.ub.gov.mn/ 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байршуулан сонгон шалгаруулалтыг явуулсан.</p>	95

	<p>худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.</p>				<p>хэмжээг цахим системд бүрэн тайлагнасан байна.</p>	<p>Мөн “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр-2” төслөөс зарласан “СЕР-1: Дамбадаржаа дэд төвийн 83 дугаар шугамын ус түгээх байрны тохижилтын ажил” гүйцэтгэх тендерт тус газрын мэргэжилтэн Г.Энхжаргал, Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа "Ногоон Улаанбаатар орон сууц төсөл"-ийн тендер болон Баянхошуу дэд төвийн В15 талбарын нарны цахилгаан үүсгүүр болон цэнэг хуримтлуулах систем, Шархад дэд төвийн S27/5 талбарт нарны цахилгаан үүсгүүр угсрах, суурилуулах ажил гүйцэтгэх тендер, Шархад дэд төвийн S27/2 талбарын гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил гүйцэтгэх тендер, Баянхошуу дэд төвийн В-13/1 болон В-13/2 талбарын инженерийн байгууламж, салбар шугам сүлжээний ажил гүйцэтгэх тендерт мэргэжилтэн Ч.Чулуунгэрэл нар оролцож байна.</p>	
4.22	<p>Нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, Дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх Шуурхай штабыг мэдээлэл, холбогдох үүргийн хэрэгжилтийг тухай бүр хангаж, тайлагнана.</p>	-	Хэрэгжилтийн хувь	-	100%	<p>Агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах ажлын хүрээнд Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлтөөс үүдсэн эерэг өөрчлөлтийн тоон мэдээллийг бэлтгэн Засгийн газрын шуурхай штаб болон холбогдох байгууллагуудад танилцуулсан. 2024,2025 оны 1 дүгээр сарын харьцуулалтаар PM2.5, PM10 бохирдол хотын хэмжээнд 1.3%, тухайн бүсэд 22.1% буурсан нь шууд нөлөөтэй гэж үнэлэгдэв.</p> <p>Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаалын дагуу байгуулсан ажлын хэсгийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран орон сууцжуулах төслүүдийн цахилгаан, дулааны хэрэглээний өсөлт, дэд бүтцийн байршил, шаардлагатай ажлын тоо болон хөрөнгө оруулалтын хэмжээг тооцож, удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллав.</p> <p>Үндэсний баялагийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороонд 2032 он хүртэлх орон сууцны төслүүдийн төлөвлөгөөг танилцуулж, ипотекийн зээлийн журмын</p>	90

						<p>өөрчлөлтийн талаар санал боловсруулсан. Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ипотекийн зээлийг бүсчилж олгох, мөн газар чөлөөлсөн иргэдийг зорилтот бүлэгт хамруулан эхний ээлжинд зээл авах боломжийг бүрдүүлэх саналыг хүргүүлэв.</p> <p>Улаанбаатар хотод хэрэгжиж буй 14 мега төслүүдээс орон сууцжуулах үйл ажиллагаатай холбоотой Ханын материал болон Баянхошуу орон сууцжуулах төсөлтэй холбоотой мэдээллээр нийслэлийн Шуурхай штабын хуралд танилцуулга мэдээлэл хийж ажиллаж байна.</p>	
<p>Зорилт 5. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллыг нийгмийн болон инженерийн дэд бүтцээр хангагдсан орон сууцны хороолол болгон хөгжүүлж, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.</p>							
5.1	<p>Хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ажлын даалгаврын дагуу төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, төсөл хэрэгжүүлэх эрх олгох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавина.</p>	-	<p>Төслийн тоо /хэсэгчилсэн талбай/</p>	60	65	<p>НИТХ-ын 2024 оны 24/16 дугаар тогтоолоор “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК байгуулагдаж, дүрмийн хүрээнд дээд байгууллагын шийдвэрээр эрх шилжсэн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгуудыг буулган шинээр барих үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд нийслэлийн Засаг даргын 14 удаагийн захирамжаар ашиглалтын шаардлага хангахгүй нийт 82 орон сууцны барилгыг буулган шинээр барих үүргийг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д, мөн 14 барилгын дахин барилгыг зохион байгуулах үүргийг Нийслэлийн Орон сууцны корпорац ХК-д тус тус даалгав.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны захирамжаар төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдаж, эхний 27 байршилд нээлттэй урилга зарлан, 14 орон сууцны төсөл хэрэгжүүлэгчийг шалгаруулан батламжилсан.</p> <p>2025 оны 11 дүгээр сарын 6-нд “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан аж ахуйн нэгжүүд болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран “Бизнес ба боломж” арга хэмжээг зохион байгууллаа.</p>	90

5.2	<p>Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж, хагас, бүтэн жилээр тайлагнана. /ХББОСЯ, ЭХЯ, НЗДТГ/</p>	-	Гүйцэтгэлийн хувь	-	100%	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр хорооны Засаг дарга нартай хийсэн уулзалтаар өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд “Айл өрхийн газрыг чөлөөлөөд олон иргэнийг амьдрах орон гэргүй болгосон төслүүдийн талаар танилцуулга хийх”-ийг Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт даалгасны дагуу “Гэр хорооллын дахин төлөвлөлт, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин барих ажлын хүрээнд иргэдийг амьдрах орон гэргүй болгосон асуудлын талаар” 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 9 дүгээр хуралд танилцуулсан.</p>	100
5.3	<p>Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үл ажиллагааны хүрээнд Нийслэлийн Засаг дарга, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч болон төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдтэй гурван талт гэрээ байгуулах, дуусгавар болгох ажлыг зохион байгуулах, байгуулсан гурван талт гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.</p>	-	Гэрээний гүйцэтгэлийн хувь	100%	100%	<p>Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны хүрээнд төсөл хэрэгжүүлэгч, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч болон Нийслэлийн Засаг даргатай нийт 58 гурван талт гэрээг шинээр байгуулсан байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаар 40 төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн нийт 1243 гурван талт гэрээ тус газарт хадгалагдаж байна. Гурван талт гэрээг дүүргээр авч үзвэл Баянгол 39, Баянзүрх дүүргийн 692, Сүхбаатар дүүргийн 70, Сонгинохайрхан дүүргийн 308, Хан-Уул дүүргийн 115, Чингэлтэй дүүргийн 46 гурван талт гэрээ тус тус эзлэж байна.</p> <p>2025 онд төсөл хэрэгжүүлэгч нарын хооронд байгуулсан гэрээний үүрэг хангагдаж нийт 144 гурван талт гэрээг дүгнэсэн. Үүнд: Батхэрэйд ХХК 20, Бүргэд констракшн ХХК 9, Шинэ гэр түншлэл ХХК 2, Зургаан талт ХХК 3, Стандарт проперти групп ХХК 5, Гангар инвест ХХК 1, Би си кей си ХХК 25, ТОСК ТӨХХК 25, Жи Ди ХХК 20, Гурван Бухат ХХК 14, Жигүүр Гранд ХХК 20 гурван талт гэрээг тус тус дүгнэсэн байна.</p> <p>Гурван талт гэрээ цуцлах тухай талуудын гаргасан өргөдөл хүсэлтийн дагуу Андын зам констракшн ХХК 6 , Назу проперти ХХК 8, Стандарт проперти групп ХХК 15, Хера пропертийз ХХК 6, Бармон ХХК 2, Мөнгөн тулга цамхаг</p>	85

						ХХК 5, Монкон групп ХХК 1, Очирням проперти ХХК 1, Грийн ресурс констракшн ХХК 2, Гурван бухат ХХК 3, Басмаа констракшн ХХК 1 нийт 50 гурван талт гэрээг цуцласан байна. Дүгнэсэн болон цуцалсан гурван талт гэрээний дагуу урьдчилсан тэмдэглэгээ цуцлуулах тухай холбогдох албан бичгийг харьяа дүүргийн Улсын бүртгэлийн газар болон Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, иргэнд холбогдох материал, гэрээ гэрчилгээг эх хувиар нь акт үйлдэн хүлээлгэн өгөөд байна.	
5.4	“Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөгөөр даалгасан үйл ажиллагааны биелэлтийг хэрэгжүүлж, тайлагнана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	70%	90%	“Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/903, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/1877 дугаар албан бичгээр тус тус Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	90
5.5	Хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаатай холбогдох судалгааг тогтмол шинэчилж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлнэ.	-	Судалгааны тоо	10	10	Хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай дараах судалгааг авч, тогтмол шинэчлэн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж ажиллаж байна. Үүнд: 1. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүж буй аж ахуй нэгжүүдээс 2025, 2026, 2027, 2028 онд нийт төсөл хэрэгжүүлэгчдийн ашиглалтад оруулах орон сууцны тоог нэгтгэн гаргасан. 2. 2025 оны эхний хагас жилийн байдлаар газар чөлөөлөлтийн тоог нэгтгэн гаргасан. 4. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд батлагдсан 26 байршил 83 хэсэгчилсэн талбай дахь ажлын явцын мэдээлэл төсөл хэрэгжүүлэгч тус бүрээр нэгтгэн гаргасан. 5. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүж буй аж ахуй нэгжүүдээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар ашиглалтад оруулсан орон сууцны тоог нэгтгэн гаргасан. 6. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд батлагдсан, дүгнэсэн, цуцалсан гэрээний тоон мэдээг нэгтгэн гаргасан. 7. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” 32 дугаар тогтоолд “ТОСК БОНД”-ын барьцаанд байгаа	90

						БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Ногоон нуур 1008 айлын орон сууц” төслийн барилга байгууламжийг зах зээлд худалдан борлуулах талаар зах зээлийн үнийн судалгаа хийж, хотын удирдлагуудад танилцуулсан.	
5.6	Дээд шатны байгууллага, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж, Зөвлөлөөс өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хангана.	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	<p>Тайлант хугацаанд дээд шатны байгууллага, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулах асуудлын хүрээнд дараах асуудлын тоон мэдээлэл, холбогдох материалыг бэлтгэн удирлагад танилцуулж, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, Орон сууцны 14 дүгээр хороолол орчмын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах “3” хэсэгчилсэн талбай дэх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцэн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулан 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 16 дугаар тэмдэглэл гарч Зөвлөлөөс өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 13 дугаар хурлын шийдвэрийг харгалзан нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12 дугаар хорооны нутаг дэвсгэр, Орон сууцны VII хорооллын орчимд нийслэлийн төсвийн хөрөнгөөр чөлөөлсөн 146 нэгж талбарыг бүртгэх, хамгаалах, газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлэхээр бэлтгэл арга хэмжээг зохион байгуулан захирамжийн төсөлд санал авч байна.</p> <p>Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн төслийн нэг, хоёрдугаар үе шатанд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд Нийслэлийн дамжуулан зээлдүүлэх зээлийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, шугам сүлжээнүүдийг байнгын ашиглалтыг хариуцах байгууллагын өмчид бүртгүүлэх, балансаас балансад шилжүүлэх, эдгээр хөрөнгүүдийн зээлийн эргэн төлөлтийг хариуцах асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж 2025 оны 02 дугаар</p>	90

						сарын 14-ний өдрийн 04 дугаартай хурлын тэмдэглэл гарсан. “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийн бүрэлдэхүүн 1-ийн хүрээнд 220 өрхийн ногоон орон сууц буюу Баянхошуу дэд төвийн 4 блок 110 айл, Шархад дэд төв 3 блок 110 өрхийн ногоон орон сууцны барилга угсралтын ажил дуусаж 2025 оны 3 дугаар улиралд улсын комисст хүлээлгэн өгсөн ба Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн Орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай 25/121 дугаар тогтоолоор 800 айлын орон сууцны барилга байгууламжийг холбогдох хууль, журмын дагуу ашиглагч байгууллагаар хүлээн авахыг Нийслэлийн Орон сууцны корпорацид даалгасан. Дээрх тогтоол гарсантай холбогдуулан 800 айлын орон сууцны барилга байгууламжийг хүлээлгэн өгөх тухай Нийслэлийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/1619 дүгээр захирамж гарсан.	
5.7	“Хотын стандарт”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох стандартуудыг төсөл хэрэгжүүлэгч нарт танилцуулж, сурталчилна.	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	Байгууллагын чиг үүргийн хүрээнд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн ажлын явцтай танилцах, хяналт тавих, ажил эрчимжүүлэх зорилгоор 2025 оны жилийн эцсийн байдлаар барилгын үйл ажиллагаанд тавигдах стандартын мэдээллийг “Хотын стандарт”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэвийн үргэлжилж буй 34 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл өгч гарын авлага хүргүүлсэн.	90
5.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим	-	Гүйцэтгэлийн хувь	171	68	Тайлант онд Шилэн дансны цахим системд тавигдах ёстой нийт 171 мэдээллээс тайлант хугацаанд 170 мэдээллийг хугацаандаа оруулж, 1 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан. Гүйцэтгэлийн хувь 99,2 % байна.	99

	хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.						
5.9	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн Засаг дарга, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч болон төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдтэй 2 болон гурван талт гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, байгуулсан хоёр, гурван талт гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	<p>Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны хүрээнд төсөл хэрэгжүүлэгч, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч болон Нийслэлийн Засаг даргатай нийт 58 гурван талт гэрээг шинээр байгуулсан байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаар 40 төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн нийт 1243 гурван талт гэрээ тус газарт хадгалагдаж байна. Гурван талт гэрээг дүүргээр авч үзвэл Баянгол 39, Баянзүрх дүүргийн 692, Сүхбаатар дүүргийн 70, Сонгинохайрхан дүүргийн 308, Хан-Уул дүүргийн 115, Чингэлтэй дүүргийн 46 гурван талт гэрээ тус тус эзлэж байна.</p> <p>2025 онд төсөл хэрэгжүүлэгч нарын хооронд байгуулсан гэрээний үүрэг хангагдаж нийт 144 гурван талт гэрээг дүгнэсэн. Үүнд: Батхэрэйд ХХК 20, Бүргэд констракшн ХХК 9, Шинэ гэр түншлэл ХХК 2, Зургаан талт ХХК 3, Стандарт проперти групп ХХК 5, Гангар инвест ХХК 1, Би си кей си ХХК 25, ТОСК ТӨХХК 25, Жи Ди ХХК 20, Гурван Бухат ХХК 14, Жигүүр Гранд ХХК 20 гурван талт гэрээг тус тус дүгнэсэн байна.</p> <p>Гурван талт гэрээ цуцлах тухай талуудын гаргасан өргөдөл хүсэлтийн дагуу Андын зам констракшн ХХК 6, Назу проперти ХХК 8, Стандарт проперти групп ХХК 15, Хера пропертийз ХХК 6, Бармон ХХК 2, Мөнгөн тулга цамхаг ХХК 5, Монкон групп ХХК 1, Очирням проперти ХХК 1, Грийн ресурс констракшн ХХК 2, Гурван бухат ХХК 3, Басмаа констракшн ХХК 1 нийт 50 гурван талт гэрээг цуцласан байна. Дүгнэсэн болон цуцалсан гурван талт гэрээний дагуу урьдчилсан тэмдэглэгээ цуцлуулах тухай холбогдох албан бичгийг харьяа дүүргийн Улсын бүртгэлийн газар болон Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, иргэнд</p>	90

						холбогдох материал, гэрээ гэрчилгээг эх хувиар нь акт үйлдэн хүлээлгэн өгөөд байна.	
5.1 0	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариуг хуулийн хугацаанд өгнө.	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	<p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагаатай холбоотой нийт 900 өргөдөл гомдлыг иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлснийг хүлээн авч, 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.</p> <p>Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног. Ирсэн өргөдөл гомдлын 40 орчим хувь нь газрын кадастрын нэр солиулах, 30 орчим хувь нь гурван талт гэрээ цуцлах, урьдчилсан тэмдэглэгээг цуцлуулах хүсэлт, 30 орчим хувь нь төслийн ажлын явцын мэдээлэл авах хүсэлт байна.</p>	95
<p>Зорилт 6. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт: Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртлыг багасгах, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод, төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэнэ.</p>							
6.1	Хот дахин хөгжүүлэх, дэд төвүүдийг түшиглэн орон сууцжуулах үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилна.	-	Гүйцэтгэлийн хувь	100 %	100%	<p>Нийслэл хотын хүн амын хэт төвлөрлийг сааруулах нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх, орчны бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд 6 дэд төвийн хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн ажлууд хийгдэж байна. Сэлбэ болон Баянхошуу дэд төвийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил 2023 онд 100 хувь хийгдэж дуусган бөгөөд 20'000 айлыг хангах гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Дамбадаржаа дэд төвийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 47 хувь, Толгойт дэд төвийн гүйцэтгэл 39 хувь, Дэнжийн мянга дэд төвийн гүйцэтгэл 7.6 хувь Шархад дэд төвийн гүйцэтгэл 11 хувийн хэрэгжилттэйгээр дэд бүтцийн бүтээн байгуулалт үргэлжилж байна. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сард</p>	90

						<p>“Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль”-ийг баталсан. Тус хуульд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дэд төвийн байршилд гэр хорооллыг тэргүүн ээлжид орон сууцжуулахаар тусгасан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14, 15 дугаар хорооны нутаг дэвсгэр, Сэлбэ дэд төв орчмын 158 га талбай, Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 28, 40 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Баянхошуу дэд төв орчмын 162 га талбайд гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр хэмжээ, хил зааг, зориулалтыг тогтоосон талаарх мэдээллийг иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажилласан.</p> <p>Мөн Баянзүрх дүүргийн 14, 38, 42 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчид болох Баганат өргөө ХХК, Гангар инвест ХХК, Шинэ гэр түншлэл ХХК, Моннис урбан девелопмент ХХК, Цагаан хуаран консалтинг ХХК, Зургаан талт ХХК, Бүрд констракшны гэр хорооллын дахин төлөвлөлт ХХК-ийн төслийн өнөөгийн нөхцөл байдал, төслийн үйл ажиллагаанд тулгарч байгаа асуудал, Баянзүрх дүүргийн хэмжээнд сургууль цэцэрлэгийн барилгын ажил болон төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх нээлттэй хэлэлцүүлгийг харьяа Засаг захиргааны нэгжийн удирдлагууд болон нийслэлийн холбогдох байгууллагуудын төлөөлөл, төсөл хэрэгжүүлэгч иргэдийн хооронд 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр Баянзүрх дүүргийн иргэний танхимд зохион байгуулан нэгдсэн мэдээллээр ханган, цаашид авах арга хэмжээний чиглэлийг гаргасан.</p>	
6.2	Байгууллагаас ирүүлсэн албан бичиг, иргэдээс ирүүлсэн өргөдөл,	-	Шийдвэрлэлтийн хоногийн тоо	6.11	5	Хөтлөх хэргийн жагсаалтын хүрээнд 2024 оны архивын баримт материалыг 2025 оны 01 дүгээр улиралд багтаан байгууллагын архив бичиг баримт хариуцсан мэргэжилтэнд	100

	<p>гомдлыг хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авах, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөн ажиллах, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, өргөдөл гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авах, хэрэгжилтийг хангаж ажиллах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивт баримт материал хүлээлгэн өгч, ил тод, нээлттэй мэдээлнэ.</p>					<p>хүлээлгэн өгсөн. Иргэн, аж ахуй байгууллагуудаас ирүүлсэн 900 өргөдөл, гомдлыг хуульд заасан бүхий л хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэн ажилласан. Мөн "Цахим Улаанбаатар" төслийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийн ulaanbaatar.erp цахим системийн функцуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах, ирсэн болон явсан албан бичгийг хугацаанд нь бүртгэж шилжүүлэн, шийдвэрлэж ажиллаж байна. Хэлтсийн нийт албан хаагчдын ажлын цаг ашиглалт 100 хувь, тасалсан, хоцорсон албан хаагч байхгүй. Тайлант хугацаанд edoc.ulaanbaatar.mn цахим системээр ирүүлсэн 1451 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Хариутай албан бичиг 180 бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлт 100%. Хариугүй албан бичиг 1264 ирсэн байх бөгөөд хугацаандаа шийдвэрлэгдсэн 1240, судалж байгаа 34 албан бичиг байна. Шийдвэрлэлтийн хувь 99,89%.</p> <p>Тайлант хугацаанд төрийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хандсан нийт 1903 албан бичгийг төлөвлөн хүргүүлж ажилласан байна.</p> <p>2025 оны жилийн эцсийн байдлаар Байгууллагаас ирүүлсэн албан бичиг 1451 ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног байна.</p>	
6.3	<p>Байгууллагын үйл ажиллагааны талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулна.</p>	-	Хамрагдсан хүний тоо	2600	2650	<p>Байгууллагаас мэдээлэл авч үйлчлүүлэхээр ирсэн болон утсаар мэдээ мэдээлэл авсан иргэдээс үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, нэгтгэн, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 2800 орчим иргэдэд үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх эрх авсан Эх газрын жигүүр ХХК, Хур Алтан Өргөө ХХК, Материал импекс ХК болон Этүүгэн тэнгэр ХХК-ийн түншлэл, Эм ти сити</p>	95

						<p>инженеринг ХХК зэрэг хуулийн этгээд, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч иргэдтэй гурван талт хамтарсан уулзалт зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэгчдэд шаардлага тавин иргэдийн хохирлыг барагдуулахад анхаарч ажиллаж байна.</p> <p>Мөн Монгол улсын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 221 дүгээр тушаалаар байгуулагдсан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, үзэл баримтлалын төслүүдийг боловсруулах, холбогдох судалгаа, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий Ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж, зөвлөх үйлчилгээний байгууллагаас хуулийн үзэл баримтлалын төслийг танилцуулж, төсөл хэрэгжүүлэгч болон эд хөрөнгө өмчлөгчдийн санал сэтгэгдлийг сонсож холбогдох арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Баянхошуу дэд төвийн 20 га талбарт барилгажилтын судалгааг гүйцэтгэж, төслийн техникийн бэлтгэл ажлыг хангасан бөгөөд тус талбарын 395 хашааны газрын эздээс нийгэм эдийн засгийн судалгаа болон төсөлд оролцох сонирхлын судалгааг гүйцэтгэсэн.</p>	
6.4	Байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах	-	Арга хэмжээний тоо	2	2	<p>Хамт олны саналыг үндэслэн Газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт, 4 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулсан. Тус хорооны гишүүд, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор ёс зүйн мэдлэг олгох сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага” сэдэвт сургалтад нийт 10, 2025 оны 12 дугаар сарын 05-ний өдөр “Ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлага, хууль хэрэглээ” сэдэвт сургалтанд 25 албан хаагч тус тус оролцсон. Мөн Төрийн албаны Зөвлөлийн 30 жилийн ойн баяр 4 албан хаагчийг 2025 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд хамруулсан. Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай гарын авлага тараах материалыг бэлтгэн танилцуулсан. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.</p>	100

6.5	Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, ёс зүй, ажлын гүйцэтгэл, цаг ашиглалт, хөдөлмөрийн сахилга, дэг журмыг сахиулах, хяналт тавина.	-	Хэрэгжилтийн хувь	100 %	100%	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01, 03 дугаар албан даалгаврын “Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах төлөвлөгөө”-г гарган хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь тайлагнасан. Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын талаарх сургалтыг 3 удаа зохион байгуулж, гарын авлагыг бэлтгэн танилцуулсан.</p> <p>Мөн ажлын байранд цаг ашиглалтанд дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу тогтмол хяналт тавьж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, ажлын цагийн бүртгэлийн төхөөрөмж шинэчилсэн. Тайлант хугацаанд ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ёс зүйн зөрчилгүй, албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажилласан.</p>	100
6.6	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, албан хэргээ кирилл, үндэсний хос бичгээр хөтлөн, Албан хэрэг хөтлөлтийн ulaanbaatar.erp цахим системийн функцуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах, ирсэн болон явсан албан бичгийг хугацаанд нь бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэнэ.	-	Үнэлгээний хувь	98.3 %	100%	<p>Албан хэрэг хөтлөлтийн ulaanbaatar.erp цахим системийн функцуудыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах, ирсэн болон явсан албан бичгийг хугацаанд нь бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэнэ.</p> <p>Тайлант хугацаанд edoc.ulaanbaatar.mn цахим системээр ирүүлсэн 563 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Үүнээс байгууллагын хаягаар 375, системээр 176, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 12 албан бичиг ирсэн тус тус ирсэн байна. Хариутай албан бичиг 30 бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлт 100%. Хариугүй албан бичиг 533 ирсэн байх бөгөөд хугацаандаа шийдвэрлэгдсэн 29, судалж байгаа 1 албан бичиг байна. Шийдвэрлэлтийн хувь 100%. Албан бичиг шийдвэрлэлтийн дундаж хоног 4.26 хоног байна.</p>	100

						Төрийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хандсан нийт 1037 албан бичгийг кирилл, үндэсний хос бичгээр хөтлөн төлөвлөн хүргүүлсэн. Тайлант хугацаанд www.erp.ulaanbaatar.mn системээр газрын үйл ажиллагаатай холбоотой нийт 1451 бичиг ирсэн, Явуулсан албан бичиг 1903. Үүнээс Хариутай албан бичиг 180. Хариугүй албан бичиг 1271 бичиг байна.	
НИЙТ ҮНЭЛГЭЭ-94%							

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
(албан тушаал)

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

.....
(гарын үсэг)

/Х.НЯМБААТАР/
(нэр)

Тамга

.....
(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

.....
(гарын үсэг)

/Ж.БОЛОРТУЯА/
(нэр)

Тамга

.....

Дэлгэрэнгүй мэдээлэл авах:

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Х. Чанцалдулам

Хаяг утасны дугаар:

Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг 23-р хороо Арцатын ам Наадамчдын зам 1201, 70110733

